



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 20 өдөр

Дугаар 5/15


Ховд

Сахилгын шийтгэл ногдуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.3.2, Захиргааны ерөнхий хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, 26 дугаар зүйлийн 26.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Боловсролын байгууллагын үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангаагүй, сургуулийн удирдлагыг удаа дараа өөрчилсөн, холбогдох хууль тогтоомжуудыг сахин биелүүлээгүй, шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийг биелүүлэхээс татгалзсан, чиг үүргээ хангалтгүй биелүүлсэн тул Ховд сумын Засаг дарга Я.Өмирханд үндсэн цалинг 10 хувиар нэг сарын хугацаанд хасах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2. Хууль тогтоомжоор хүлээсэн бүрэн эрхээ хэрэгжүүлж, үүрэг хариуцлага, ажлын үр дүнгээ сайжруулан, холбогдох албан тушаалтнуудаа мэргэжил, арга зүйгээр хангаж, дахин зөрчил, дутагдал гаргахгүй ажиллахыг Ховд сумын Засаг дарга (Я.Өмирхан)-д үүрэг болгосугай.



Б.ДҮГЭРЖАВ

8400 01 За 1553